



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулахыг дэмжих тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 91 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А-1/512 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсүгэй.
 - 1.1. 1.4-д “Компани нь 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар” хэрэгжүүлнэ. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллана.” гэж;
 - 1.2. 2.2 -д “Компанийн оноосон нэр нь монголоор “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “ТООК” ТӨХХК, англиар “State Housing Corporation of Mongolia” State-Owned Limited Liability Company, товчилсон нэр нь “State Housing Corporation of Mongolia” SOLLC болно.” гэж;
 - 1.3. 8.1-д “Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар” хэрэгжүүлнэ.” гэж;
 - 1.4. 8.5-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалтад заасны дагуу сонгоно.” гэж;
 - 1.5. 10.1-д “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-нд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр дутамын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн Гүйцэтгэх захирал байна.” гэж;

- 1.6. 10.2-д “Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулж, томилох, чөлөөлөх, бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ” гэж;
- 1.7. 10.3-д “Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” байгуулна. Гэрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-нд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.” гэж;
- 1.8. 10.6-д “Гүйцэтгэх захирал нь компанийн ерөнхий нягтлан бодогчийг томилж, чөлөөлөхдөө Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.” гэж;
- 1.9. 14.2-д “Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.” гэж;

2. Дүрмийн дараах заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

- 2.1. 1.5-д Компани нь “Эрчист Монгол” ТӨХХК-ийн охин компани бөгөөд нэгдлийн зарчмаар менежментийн гэрээ байгуулан ажиллаж, менежментийн төлбөрийн хувь хэмжээг компанийн борлуулалтын орлогын 1 (нэг) хувь хүртэл байхаар тогтооно.
- 2.2. 1.6-д Компани нь “Эрчист Монгол” ТӨХХК-ийн хууль, тогтоомжийн хүрээнд баталсан дүрэм, журам, стратеги төлөвлөгөө, зөвлөмж, бодлогын баримт бичиг зэргийг мөрдөж ажиллана.
- 2.3. 10.5-д Гүйцэтгэх захиралыг томилох, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

3. Дүрмийн өөрчлөлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч (Б.Лхагва-Очир)-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга (Л.Амгалан)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА